



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/136

Улиастай

2017 оны нэгдүгээр ээлжийн цэрэг  
татлагыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.9, 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2017 оны мн/52 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2017 оны н/127 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны нэгдүгээр ээлжийн Цэрэг татлагын товчоог дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Товчооны дарга	Л.Лхамсүрэн	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга	Г.Нэмэхбаяр	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
Гишүүд	С.Цэрэнсамбуу	-Аймгийн Цагдаагийн газрын дарга
	Ч.Дэмчигсүрэн	-Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
	И .Батсайхан	-Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасгийн дарга
	Г.Бавуудорж	-Цэргийн штабын офицер
Нарийн бичгийн дарга	Ц.Нацагдорж	-Цэргийн штабын офицер

2.Хоёдугаар ээлжийн цэрэг татлагыг 2017 оны 04 дугаар сарын 19-өөс, 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд бүх сумдад зохион байгуулах ажлын хэсгийн

бүрэлдэхүүнийг удирдлагаар хангахыг цэрэг татлагын товчооны дарга /Л.Лхамсүрэн/-д даалгасугай.

3.Цэргийн жинхэнэ албанд татагдсан иргэдэд эрүүл мэндийн үзлэгийг чанартай явуулж мэргэжлийн эмч, техник хэрэгслэлээр ханган ажиллуулахыг аймгийн Эрүүл мэндийн газар /Ч.Дэмчигсүрэн/-т, Цэрэг татлагын комиссын үзлэг явагдаж байгаа сум /байр/-т цагдаагийн ажилтанг томилон ажиллуулах, хэв журам сахиулах, цэргийг тээвэрлэх үеийн аюулгүйн ажиллагааны зааварчилгаагаар ханган ажиллахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа С.Цэрэнсамбуу/-т тус тус хариуцуулсугай.

4.Цэргийн штабаас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу хууль хяналтын байгууллагатай хамтран цэрэг татлагын ажлыг зохион байгуулж, хуваарьт өдөр, тогтоосон цагт хүмүүсээ бүрэн хамруулж цэргийн жинхэнэ албанд тэнцсэн иргэдийг аймагт ирүүлэх, халагдан ирэгсэдийг суманд хүргэх тээврийн хэрэгслэлийн бүрэн бүтэн байдал аюулгүйн ажиллагааг бүрэн хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Цэрэг татлагын арга хэмжээнд зарцуулах 6957100 /зургаан сая есөн зуун тавин долоон мянга нэг зуун долоон зуун/ төгрөгийг хавсралтаар баталж гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Л.Лхамсүрэн/-т зөвшөөрсүгэй.

6.Ээлжит цэрэг татлага явуулсан дунг сум тус бүрээр нэгтгэж 2017 оны 05 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргад танилцуулж, гарсан шийдвэрийг сум, холбогдох байгууллагуудын дарга нарт хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг цэрэг татлагын товчооны орлогч дарга /хурандаа Г.Нэмэхбаяр/-т үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ж.Хүрэлбаатар/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАТСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2017 оны 04 дугаар сарын 04-ны өдрийн ...А/136.....дугаар тоот захирамжийн хавсралт

№	Зардал /зүйл/-ийн нэр	Хүний тоо	Зориулж гаргах хөрөнгийн тооцоо	Дүн Мян/төг
1	2017 оны I ээлжийн цэрэг татлага явуулах сумын тоо -24	ЗДТГ-аас 4 Эмч-6	Шатахуун тослох материалын үнэ $1741\text{км} \times 20.5 = 355\text{л} \times 1650\text{төг} = 585750\text{ төг}$	585750
2	Улаанбаатар хотод гэрээт цэрэг хүргэх, дотор явах комиссын машины бензиний үнэ	Цэргийн штабаас-3 Жолооч-1	$2000\text{км} \times 15\text{л} = 300\text{л} \times 1890\text{төг} = 567000\text{ төгрөг}$	567000
3	Комиссын бүрэлдэхүүний ажлын хөлс /томилолт/	10	$12000 \times 11\text{хоног} = 132000\text{т} \times 10\text{хүн} = 1320000\text{төг}$	1320.0
4	Улаанбаатар хотод гэрээт цэрэг хүргэж өгөх комиссын томилолт Цэргийн штабаас офицер-3, жолооч-1	4	$35500 \times 7 = 248500 \times 3 = 745500\text{ төг}$ $16000 \times 7 = 112000 \times 1 = 112000 + 745500 = 857500$	857500
5	Эмч нар цэрэг татлагын комиссын хоолны зардал	15	Өдөрт 1-удаа 1,2-р хоол өгнө. 1хүн өдөрт $8000\text{төг} \times 15\text{хүн} = 120000\text{ төгрөг}$	120000
7	Цэргийн албанд татагдагсадыг сумаас аймаг, халагдсан цэргийг суманд хүргэх	Татагдах 155 Халагдах 135	$2020\text{л} \times 1650\text{төг} = 3332850\text{төгрөг}$	3332850
8	Тооцооны хуудас	370	$370 \times 200 = 74000\text{ төг}$	74000
Дүн = 6957100 төгрөг				

ЦЭРГИЙН ШТАБ